



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/133

Ховд

Иргэн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг  
түр хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", 29.1.6-ын "а", "л" заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн, аймгийн Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаанбаатар хот болон бусад аймаг орон нутагт коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тархалт ихсэж байгаатай холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт халдвар тархахаас урьдчилан сэргийлж хот хоорондын тээврийн хэрэгслийн болон иргэдийн хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 08:00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цаг хүртэл түр хязгаарласугай.

2. Албан томилолт, эрүүл мэндийн шалтгаан /А13 маягттай/, ар гэрийн гачигдал, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнс, шатахуун, өвс тэжээл тээвэрлэх үйл ажиллагааг нотлох баримтыг үндэслэн тусгай зөвшөөрөл олгож, хяналтын цэгээр нэвтрүүлж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комиссын орлогч, хурандаа /Б.Алтанбадралт/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /Б.Алтанбадралт/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/133 Ch

02 0970